ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөдөө аж ахуйн халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/424/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер Э.Энхбаатар<br>Утас: 260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn<br>Аудитор П.Ариунзаяа<br>Утас: 261885 Цахим хаяг: ariunzayap@audit.gov.mn<br>Цэгцтөв богд аудит ХХК-ийн захирал Н.Цэрэнханд<br>Утас: 99901517 Цахим хаяг: tsegtstuvbogd@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/671
танай ____________-ны №______________-т

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БҮСИЙН ЗАХИРГААНЫ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ЭНХНАСАН ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний 2,700.0 мянган төгрөгийг бүрдүүлээгүй, зардлын эдийн засгийн ангилал баримтлалгүй 23,380.0 мянган төгрөг зарцуулсан, цалин амралтыг давхардуулан тооцож 1,782.1 мянган төгрөгийн цалин олгосон, шатахуун зарцуулалтын норм мөрдөлгүй 1,482.9 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан, малчин иргэнтэй холбоотой 87,110.0 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй, эд хөрөнгийн тооллогын дүнг 14,728.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, төсвийн хөрөнгийг төрийн бус байгууллагад гэрээ байгуулж 9,980.0 мянган төгрөг олгосон зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй болович өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.1 "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4. “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох

акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Засгийн газрын 2024 оны 32 дугаар хуралдааны тэмдэглэлд ХХААХҮЯ болон түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлнэ гэж даалгасны дагуу тус бүсийн захиргааг Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1 дүгээр багт шилжүүлж 15,940.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Дорнод аймгийн Халх гол сум дахь тусгай хэрэгцээний газарт Засгийн газрын 2022 оны "Мал эмнэлгийн дэглэм бүхий, хорио цээрт эрүүл бүс байгуулах талаар авах арга хэмжээний тухай" 424 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд бүс байгуулах газрын төлөвлөлтийг хийж, "Хамгаалагдсан аж ахуй" байгуулах төсөл сонгон шалгаруулах ажлыг ХХААХҮЯ-тай 2 удаа зохион байгуулсан ч бүсийн тусгай хэрэгцээний газартай 2019 оны 41 дүгээр тогтоолоор тусгай хамгаалалтад авсан Нөмрөгийн дархан цаазат газрын өргөтгөл 28,863.25 га, Ташгай таван нуур байгалийн нөөц газар 93,565.3 га газар тус тус давхацсан тул сонгон шалгаруулалтыг зогсоосон байна.

**Бусад асуудал**

Тус бүсийн захиргааны боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллаагүй тул аудитор нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ мэдээллээр бүрэн хангагдах зарчмын хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байлаа.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА-693 9006109
9023030583

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-28.Docx

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 557,823,167.88 | 128,490,092.50 |
| 33 | АВЛАГА | 94,476,739.13 | 88,619,742.50 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 7,366,739.13 | 1,509,742.50 |
| 335 | Бусад авлага | 87,110,000.00 | 87,110,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 87,110,000.00 | 87,110,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 463,346,428.75 | 39,870,350.00 |
| 351 | Түүхий эд материал | 397,504,878.75 | 800,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 397,504,878.75 | 800,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 14,621,550.00 | 2,900,350.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 33,000.00 | 33,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,773,550.00 | 2,022,550.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 748,800.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 96,000.00 | 96,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,719,000.00 | - |
| 35600 | Мал амьтад | 51,220,000.00 | 36,170,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,724,101,075.03 | 1,505,706,152.95 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,724,101,075.03 | 1,505,706,152.95 |
| 392 | Биет хөрөнгө | 1,724,101,075.03 | 1,429,896,150.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,759,168,391.00 | 2,431,853,114.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,390,863,408.83) | (1,542,327,370.31) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 218,397,424.10 | 218,397,424.10 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (84,640,406.97) | (111,685,810.29) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 235,680,782.52 | 520,819,717.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (25,962,132.95) | (95,175,694.85) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,191,480.12 | 20,416,480.12 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,055,053.96) | (13,493,709.95) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,184,000.00 | 2,184,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (1,092,000.00) |
| 393 | Биет бус хөрөнгө | - | 75,810,002.28 |
| 39301 | Программ хангамж | 2,600,000.00 | 2,600,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,600,000.00) | (2,600,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 79,800,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (3,989,997.72) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,281,924,242.88 | 1,634,196,245.45 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1.00 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1.00 | - |
| 413 | Өглөг | 1.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,281,924,241.91 | 1,634,196,245.45 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,281,924,241.91 | 1,634,196,245.45 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,281,924,241.91 | 1,634,196,245.45 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,703,827,521.43 | 2,281,924,241.91 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 578,096,720.48 | (647,727,996.46) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,281,924,242.91 | 1,634,196,245.45 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,266,601,664.62 | 1,011,083,221.90 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 735,073,564.62 | 296,367,521.90 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 735,073,564.62 | 296,367,521.90 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 18,720,000.00 | 6,450,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,100,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 18,720,000.00 | 5,350,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 701,353,564.62 | 289,417,521.90 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 15,000,000.00 | 500,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 531,528,100.00 | 714,715,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 526,848,100.00 | 713,615,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 526,848,100.00 | 713,615,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,680,000.00 | 1,100,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,680,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 1,100,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 688,504,944.14 | 1,014,591,062.61 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 688,504,944.14 | 1,014,591,062.61 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 615,991,411.01 | 886,699,695.17 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 322,456,851.93 | 426,273,958.10 |
| 210101 | Үндсэн цалин | 204,963,893.44 | 259,028,161.10 |
| 210102 | Нэмэгдэл | 50,531,939.99 | 108,404,797.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,059,995.07 | 34,610,000.00 |
| 210104 | Урамшуулал | 32,197,066.83 | 24,231,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,703,956.60 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 42,592,369.43 | 54,904,736.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,963,142.72 | 38,697,354.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,468,595.41 | 4,598,642.96 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,430,777.01 | 2,805,261.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 845,863.77 | 1,757,167.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,883,990.52 | 7,046,309.30 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,000,555.58 | 3,617,573.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,460,010.58 | 1,032,683.95 |
| 210302 | Түлш, халаалт | - | 873,370.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 540,545.00 | 171,020.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,000,000.00 | 1,540,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,039,136.80 | 37,288,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,102,086.80 | 1,009,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,271,600.00 | 11,658,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,110,700.00 | 846,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,554,750.00 | 2,874,200.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 20,900,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,661,100.00 | 10,886,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,661,100.00 | 10,886,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,973,200.00 | 10,836,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,973,200.00 | 10,836,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 47,501,855.00 | 70,495,460.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40,620,200.00 | 57,037,860.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 547,775.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 172,500.00 | 215,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 180,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,981,380.00 | 8,220,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 165,766,342.27 | 272,396,166.98 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,705,600.00 | 11,719,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 147,060,742.27 | 260,677,166.98 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 72,513,533.13 | 127,891,367.44 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,794,919.00 | 2,431,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,603,519.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 191,400.00 | 2,431,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 45,718,614.13 | 124,360,367.44 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 43,018,614.13 | 124,360,367.44 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,700,000.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 1,100,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,100,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 578,096,720.48 | (3,507,840.71) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 644,220,155.75 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 247,515,277.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | - | 396,704,878.75 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (644,220,155.75) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 578,096,720.48 | (647,727,996.46) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 534778100.00 | 715815700.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,250,000.00 | 1,100,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,250,000.00 | 1,100,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,250,000.00 | 1,100,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,250,000.00 | 1,100,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 531,528,100.00 | 714,715,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 526,848,100.00 | 713,615,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 526,848,100.00 | 713,615,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,680,000.00 | 1,100,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,680,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 1,100,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 534,778,100.00 | 715,815,700.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 534,778,100.00 | 715,815,700.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 462,264,566.87 | 587,924,332.56 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 329,823,590.06 | 420,433,398.05 |
| 210101 | Үндсэн цалин | 204,963,893.44 | 253,212,348.64 |
| 210102 | Нэмэгдэл | 57,460,930.36 | 108,429,049.41 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,059,995.07 | 34,561,000.00 |
| 210104 | Урамшуулал | 32,197,066.83 | 24,231,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,141,704.36 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 42,592,369.43 | 54,888,300.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,963,142.72 | 38,666,985.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,468,595.41 | 4,540,642.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,430,777.01 | 2,577,663.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 845,863.77 | 2,053,505.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,883,990.52 | 7,049,504.59 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,000,555.58 | 3,617,573.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,460,010.58 | 1,032,683.95 |
| 210302 | Түлш, халаалт | - | 873,370.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 540,545.00 | 171,020.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,000,000.00 | 1,540,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,439,896.80 | 16,386,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 735,196.80 | 1,009,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,660,000.00 | 12,407,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,101,300.00 | 846,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,943,400.00 | 2,123,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,332,100.00 | 11,266,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,275,000.00 | 784,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,057,100.00 | 10,481,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 11,584,800.00 | 10,836,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,584,800.00 | 10,836,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 47,511,255.00 | 70,495,460.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,829,600.00 | 57,037,860.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 547,775.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 172,500.00 | 215,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 180,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,781,380.00 | 8,220,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,980,000.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,980,000.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 72,513,533.13 | 127,891,367.44 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,794,919.00 | 2,431,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,603,519.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 191,400.00 | 2,431,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 45,718,614.13 | 124,360,367.44 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 43,018,614.13 | 124,360,367.44 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,700,000.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 1,100,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,100,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр дуусвар болсон* *\/төгрөгөөр*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | - | - | 1,703,827,521.43 | 1,703,827,521.43 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 1,703,827,521.43 | 1,703,827,521.43 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 578,096,720.48 | 578,096,720.48 |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 2,281,924,241.91 | 2,281,924,241.91 |
| D01 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 2,281,924,241.91 | 2,281,924,241.91 |
| D02 | Тайлант үеийн үр дүн | - | - | (647,727,996.46) | (647,727,996.46) |
| D03 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | | 1,634,196,245.45 | 1,634,196,245.45 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 725,147,900.00 | 590,355,332.56 | 134,792,567.44 | 81.4 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 725,147,900.00 | 590,355,332.56 | 134,792,567.44 | 81.4 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 713,716,500.00 | 587,924,332.56 | 125,792,167.44 | 82.4 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 531,486,800.00 | 420,433,398.05 | 111,053,401.95 | 79.1 |
| Үндсэн цалин | 310,990,300.00 | 253,212,348.64 | 57,777,951.36 | 81.4 |
| Нэмэгдэл | 126,854,200.00 | 108,429,049.41 | 18,425,150.59 | 85.5 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 45,557,600.00 | 34,561,000.00 | 10,996,600.00 | 75.9 |
| Урамшуулал | 48,084,700.00 | 24,231,000.00 | 23,853,700.00 | 50.4 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,435,600.00 | 54,888,300.56 | 11,547,299.44 | 82.6 |
| Тэтгэврийн даатгал | 45,176,200.00 | 38,666,985.21 | 6,509,214.79 | 85.6 |
| Тэтгэмжийн даатгал | 5,314,900.00 | 4,540,642.52 | 774,257.48 | 85.4 |
| ҮОМШӨ-ний даатгал | 2,657,400.00 | 2,577,663.00 | 79,737.00 | 97.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 2,657,500.00 | 2,053,505.24 | 603,994.76 | 77.3 |
| Эрүүл мэндийн даатгал | 10,629,600.00 | 7,049,504.59 | 3,580,095.41 | 66.3 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,890,900.00 | 3,617,573.95 | 2,273,326.05 | 61.4 |
| Гэрэл, цахилгаан | 2,574,100.00 | 1,032,683.95 | 1,541,416.05 | 40.1 |
| Түлш, халаалт | 1,593,900.00 | 873,370.00 | 720,530.00 | 54.8 |
| Цэвэр, бохир ус | 182,400.00 | 171,020.00 | 11,380.00 | 93.8 |
| Байрны түрээс | 1,540,500.00 | 1,540,500.00 | - | 100.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 16,635,200.00 | 16,386,200.00 | 249,000.00 | 98.5 |
| Бичиг хэрэг | 1,009,200.00 | 1,009,200.00 | - | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 12,407,700.00 | 12,407,700.00 | - | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,095,100.00 | 846,100.00 | 249,000.00 | 77.3 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,123,200.00 | 2,123,200.00 | - | 100.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 11,267,000.00 | 11,266,600.00 | 400.00 | 100.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 784,800.00 | 784,800.00 | - | 100.0 |
| Урсгал засвар | 10,482,200.00 | 10,481,800.00 | 400.00 | 100.0 |
| Томилолт, зочны зардал | 10,836,800.00 | 10,836,800.00 | - | 100.0 |
| Дотоод албан томилолт | 10,836,800.00 | 10,836,800.00 | - | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 71,164,200.00 | 70,495,460.00 | 668,740.00 | 99.1 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 57,067,500.00 | 57,037,860.00 | 29,640.00 | 99.9 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,020,300.00 | 5,000,000.00 | 20,300.00 | 99.6 |
| Даатгалын үйлчилгээ | 615,900.00 | - | 615,900.00 | 0.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 215,600.00 | 215,600.00 | - | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 24,900.00 | 22,000.00 | 2,900.00 | 88.4 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,220,000.00 | 8,220,000.00 | - | 100.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,431,400.00 | 2,431,000.00 | 9,000,400.00 | 21.3 |
| Бусад урсгал шилжүүлэг | 11,431,400.00 | 2,431,000.00 | 9,000,400.00 | 21.3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 9,000,000.00 | - | 9,000,000.00 | 0.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,431,400.00 | 2,431,000.00 | 400.00 | 100.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 725,147,900.00 | 590,355,332.56 | 134,792,567.44 | 81.4 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 721,347,900.00 | 589,255,332.56 | 132,092,567.44 | 81.7 |
| Улсын төсвөөс санхүүжих | 721,147,900.00 | 589,255,332.56 | 131,892,567.44 | 81.7 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 3,800,000.00 | 1,100,000.00 | 2,700,000.00 | 28.9 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 3,800,000.00 | 1,100,000.00 | 2,700,000.00 | 28.9 |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 21 | 9 | 12 | 42.9 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 17 | 6 | 11 | 33.3 |
| Үйлчлэх ажилтан | 3 | 2 | 1 | 100.0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 1,100,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 1,100,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 1,100,000.00 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,100,000.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,100,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 1,100,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 1,100,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 1,100,000.00 |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

**3.1** Аудитаар нийт 141,163.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 11,762.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 114,618.9 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 14,782.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эд хариуцагчийн тооцоо бодож баталгаажуулаагүй, хөрөнгийг 14,782.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 14,782.5 | | | | | 1 | 14,782.5 | | | | |
| Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 2,700.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна. | 1 | 2,700.0 | | | 1 | 2,700.0 | | | | | | |
| Малчин иргэнтэй холбоотой 87,110.0 мянган төгрөгийн үнэтэй 109 толгой үхрийн дансны авлагыг барагдуулаагүй байна. | 1 | 87,110.0 | | | 1 | 87,110.0 | | | | | | |
| Нэр бүхий 3 албан хаагчид ажилласан болон амралтын хоногийг давхардуулан тооцож нийт 1,782.1 мянган төгрөгийн цалинг илүү бодож олгосон байна. | 1 | 1,782.1 | 1 | 1,782.1 | | | | | | | | |
| Зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг, ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Загвар аж | 1 | 23,380.0 | | | 1 | 23,380.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ахуйн гражийн дээврийн урсгал засварт 16,000.0 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн урсгал засварт 7,380.0 мянган төгрөг, нийт 23,380.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | | | | | | | | | | | | |
| ТЕЗ-ийн эрхлэх асуудлын төсвийн байгууллагуудад мөрдөх НБББББ-т заасан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын норм"-ыг баримтлалгүй 1,428.9 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан байна. | 1 | 1,428.9 | | | 1 | 1,428.9 | | | | | | |
| Төсвийн жил дуусаж байхад 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр "Зоргол хайрхан үр сад" ТББ, "Шударга түншлэл" ТББ-тай 2025 оны 03 дугаар сарын 01-ны өдөр дуусгавар болох гэрээ байгуулан бусад нийтлэг, ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 9,980.0 мянган төгрөгийг 12 дугаар сарын 23-ны өдөр шилжүүлж, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулжээ. | 1 | 9,980.0 | 1 | 9,980.0 | | | | | | | | |
| **Дүн** | **7** | **141,163.5** | **2** | **11,762.1** | **4** | **114,618.9** | **1** | **14,782.5** | | | | |

**3.2** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | |
| Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тодруулга, танилцуулгыг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна. | 1 | - | - | - | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | | **-** | | **-** |